



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

"Багш, ажилтны илтгэх ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн онол практикийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэх, туршлага солилцох, ажлын байранд шинэлэг санаа, сэдлийг бий болгох" зорилгоор зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд 15 багш илтгэл хэлэлцүүлж,

- 1 байранд "Суралцагчдын хандлага төлөвшлийг бий болгох сургалтын аргууд" Долгормаа, У.Оюунбаяр
- 2 байранд "Хөтөлбөрт интеграци хийх нь" Да.Солонго, Г.Жаргалсайхан
- 3 байранд "Багшийн харилцаа суралцагчийн нүдээр" Э.Наранжаргал, Б.Болор Эрдэнэ

нар шалгарлаа



МБСБ-ын захирал, удирдах ажилтнуудад Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн бодлого, зорилт, цаашдын хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулж, сургуулийн болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн туршлагаа солилцлоо



СУРГАЛТ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛ ХУРАЛДАВ

Хуралдаанаар

1. 2023-2024 оны хичээлийн жилийн элсэлтийн квотын санал, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүн, шинжилгээ,
2. Багшийн мэргэжлийн зэргийн шалгуур хангасан материалуудыг хянан хэлэлцэж шийдвэрлэх,
3. Цахим сэтгүүл болон 2022-2023 оны хичээлийн жилд хэвлэгдэх гарын авлагыг хэлэлцэн батлах,
4. Магадлан итгэмжлэгдсэн 6 мэргэжлийн хөтөлбөрийн ахиц дэвшлийн тайлантай танилцаж тус тус шийдвэрлэв.



ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

"БШУ"-ны Сайдын 2023 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ" амжилттай явагдаж өндөрлөлөө.





НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

**МСМ” ГРУПП СУРГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
ГАРДУУЛАН ӨГЛӨӨ.**



“МСМ” группийн хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд “Бэлэг дурсгалын зүйл урлаач” мэргэжлийн

суралцагчдад зориулж нарийн гар урлалын 10,0 сая төгрөгийн мэргэжлийн багаж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах хэрэгслийн хамт хүлээлгэн өглөө



**ГАДААД ХАМТЫН
АЖИЛЛАГАА.**

ОХУ-ын Буриад улсын олон түвшинт шаталсан сургалттай коллежтой хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулж олон талаар хамтран ажиллах болов.

БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ-2023 ҮЗЭСГЭЛЭН

сМишээл экспод зохион байгуулагдсан “Боловсролын шинэчлэл 2023 ” үзэсгэлэнд багш суралцагчид оролцлоо.

ЯАРМАГ ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОВ

Монголын хөнгөн үйлдвэрийн холбооноос зохион байгуулж байгаа “Хөнгөн үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн яармаг өдөрлөгт нийгмийн түншлэл, багш М.Энхтуяа болон хувцас загвар зохион бүтээгч 26 ангийн 12 суралцагчид хамрагдлаа



**СУРАЛЦАГЧИД “ӨӨРТӨӨ ЗӨВ ДАДАЛ ХЭВШҮҮЛБЕ” УРИАН
ДОР БЯЦХАН CONTENT БЭЛТГЭН ТҮГЭЭЛЭЭ**



**СУРАЛЦАГЧДЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛОВ**

“БИДНИЙ ОРОЛЦОО-БИДНИЙ ИРЭЭДҮЙ” болон “МИНИЙ СУРАХ ОРЧИНДОО НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал амжилттай зохион байгуулагдаж

1 байр: ХЗЗБ16 Г.Анударь- Суралцагч төвтэй арга зүйг сайжруулах оюутны оролцоо- Удирдагч багш: Г.Жаргалсайхан

2 байр: АХАҮА 1в Э.Энхжаргал- Хуванцар савны хэрэглээ, бидний ирээдүйд -Удирдагч багш: 3.Долгормаа нар шалгарлаа

ОЮУТНЫ U MONEY ЗАХИАЛГА



**ОЮУТНЫ U MONEY
ШИНЭ ЗАХИАЛГА**

Нэг удаа захиалаад төгсөх анги хүртлээ автобусаар зорчоорой.

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй хамтран автобусны үнэгүй зорчих эрх бүхий смарт картын нэмэлт захиалгад 89 суралцагчийг хамруулсан.



**ОЮУТАН,
СУРАЛЦАГЧДЫГ
АЖЛЫН БАЙРАНД
ЗУУЧЛАВ**



Оюутан, суралцагчдыг хичээлийн бус цагаар цагийн ажил хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор “KFC” хамтран ажлын байрны өдөрлөгийг зохион байгууллаа.

СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА



ШИНЭЭР КЛУБ БАЙГУУЛАГДЛАА

"Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой клуб" өсвөрийн клуб байгуулагдаж 18 ангийн 25 суралцагчдыг хамруулан чиглүүлэх сургалтыг зохион байгуулж, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулах зөвшөөрлийн хуудас болон оюутан суралцагчдад клубын талаарх товч танилцуулга мэдээлэл хүргэж клубын дүрэм уриагаа баталлаа.



СУРГАЛТ


"Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт" цагдаагийн урьдчилан сэргийлэх сургалт боллоо. 3-р сарын 21-нд Сүхбаатар Дүүргийн Цагдаагийн Газрын II Хэлтэс, ГБХУСАМ цагдаагийн ахлах дэслэгч Т.Отгонбаяр, ХАХМ дэслэгч Б.Халиун нартай хамтран хууль эрх зүйн сургалт зохион байгуулав. "Гэр бүлийн хүчирхийлэл ба хүүхэд хамгаалал" сэдвээр яриа таниулга хийв. Сургалтад нийт 150 суралцагч хамрагдлаа.



"03 сарын 30-нд дүүргийн Эрүүл мэндийн төв, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран "Нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Гэр бүл төлөвлөлт", "Бэлгийн ариун цэвэр", "Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх", "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдвүүдээр сургалт зохион байгуулж 6 ангийн 74 суралцагчийг хамрагдав.


СУРАЛЦАГЧДЫН ӨӨРИЙН УДИРДЛАГА

Сургуулийн "Оюутны зөвлөл" 2022-2023 оны хичээлийн хагас жилийн тайлангаа сургуулийн удирдах ажилтнуудад танилцуулав. Оюутан суралцагчдын хөгжил, төлөвшил нийгмийн оролцоонд тулгуурлан олон талт үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна. Үүнээс онцолбол "Оюутны нэг өдөр", "Мэндэлье хүндэлье аян", "Туршлага солилцох үйл ажиллагаа" "Pepero day", "Crush Box" аян, "Choco box" зэрэг үйл ажиллагаанууд байлаа.



АСРАН ХАМГААЛАГЧДЫН ЭРГҮҮЛ АЖИЛЛАВ.

Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхэддээ тавих хараа хяналтыг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах зорилгоор сургуулийн гадна орчинд II ангийн эцэг эх, асран хамгаалагчдын эргүүл зохион байгуулж хамтран ажиллаа.



СУРАЛЦАГЧИД ДЭГ ЖУРАМ САХИУЛАВ

Дэг журам сахиулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хичээлийн цагаар жижүүр ангийг зохион байгуулж 44 ангийн 923 суралцагчийг хамрууллаа. Жижүүр суралцагчид бие биедээ хүндэтгэл үзүүлж шаардлага тавьж харилцааны ур чадвараа хөгжүүлдэг байна.





СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

ЭХ ТҮҮХЭЭРЭЭ БАХАРХЪЯ




Эх орончдын өдрийг тохиолдуулан "Түүхийн ухааны доктор, профессор" Г.Энх-Амарыг урьж эх оронч үзэл, үнэт зүйл, Чингис хааны бага насны үе, авъяас чадвар, түүхэн замналын талаар ярилцаж, "Чингис хаан" контент бичлэгийг үзэж сонирхлоо.



MEETING СУРГАЛТ

Мэдээллийн технологийн хөгжил, өнөө үед ажлын байранд тавигдаж байгаа ур чадварууд болон тэдгээрийг гүнзгийрүүлэн судлах арга барилыг таниулах, суралцагчдын хандлага, төлөвшил, мэргэжилдээ хандах хандлагагыг дээшлүүлэх зорилгоор Novelsoft компанийн ахлах програмист Г.Амаржаргал болон Эм Эл Си Трейнинг ХХК-ийн менежер Б.Намуунаа нартай хамтран "БИДНИЙ МЭРГЭЖИЛ-БИДНИЙ ИРЭЭДҮЙ" уулзалт, хэлэлцүүлгийг мэдээллийн технологийн мэргэжлээр суралцаж байгаа, оюутан суралцагчдын дунд зохион байгууллаа



"НЭН ТҮРҮҮН" ХАБЭА

УУПК-ийн Тогооч, ХҮҮТТ мэргэжлийн ангиудын суралцагчдад

- Тогоочийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Ажил дуусах үеийн зааварчилгаа сэдэвт сургалтыг ХАБЭА хариуцсан ахлах ажилтан Б.Дамдинхорол, хоол үйлдвэрлэлийн багш нар хамтран зохион байгууллаа



ТӨГСӨГЧДИЙН АНХДУГААР ТЭМЦЭЭНИЙ УРИАЛГА

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн биеийн тамирын багш, спортын мастер Чулуунбатын Ариунтуяагийн нэрэмжит үе үеийн төгсөгчдийн волейболын анхдугаар тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг томилж төгсөгчдийг идэвхитэй оролцохыг уриаллаа.



ДОТУУР БАЙРНЫ СУРАЛЦАГЧИД УРИАЛГА ДЭВШҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй "Хоккейн IV Дивизионы Дэлхийн Аварга шалгаруулах тэмцээн" Мөсөн Өргөө-Steppe Arena-д зохион байгуулагдсан билээ.

Эх орноо төлөөлөн оролцож буй Монголын баг тамирчдадаа сургуулийн дотуур байранд суралцаж буй нийт 90 оюутан суралцагчид хөгжөөн дэмжиж Монгол улсынхаа тамирчдыг дэмжих уриалгыг хүргэлээ



976+11350209



Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж



www.pas.mn